



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/776

Булган сум


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, 42.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.1, 2023 оны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны “Хөтөлбөр төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг тодотгон батлах тухай” А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн хэмжээнд зохион байгуулж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн баталгааг дэмжье” сарын аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Сарын аян зохион байгуулахад шаардагдах 5,542,000 (Таван сая таван зуун дөчин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 16-ны өдрийн
А/16 дугаар захирамжийн хавсралт

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн баталгааг дэмжье”
сарын аян зохион байгуулахад шаардагдах зардал

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт үнийн дүн
Сарын аяны нээлтийн арга хэмжээ				
1	Хулдаасан хэвлэл	1ш	155,000	155,000
2	Нээлтийн арга хэмжээнд оролцогчдод хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг	20ш	5,000	100,000
Дохионы хэлний сургалт зохион байгуулах				
3	Багшийн замын зардал	Ирэх, буцах 2 удаа	42,900	85,800
4	Багшийн хоолны зардал	3 өдөр*4 удаа=12	26,350	316,200
5	Печень	80ш	1,740	139,200
6	Кофе	200ш	825	165,000
7	Цайны нэг удаагийн хэрэгсэл	5 багц	4,160	20,800
Байнгын асаргаатай хүүхдэд дэмжлэг үзүүлэх				
8	Гудас, хөнжил	57ш	80,000	4,560,000
				5,542,000